



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Санхүүгийн мэдээллийн технологийн төв УТҮГ 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/043/НА-СТА-ТӨҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2025 он</p>	<p>Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас:51-261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: П.Чанцалдулам Утас:51-261885 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn Ахлах аудитор: Ж.Нямцэцэг Утас: 51-261885 Цахим хаяг: nyamtsetsegj@audit.gov.mn Азуре хүлүг худит ХХК-ийн гүйцэтгэх захирал: Г.Мөнхбаяр Утас: 70110090 Цахим хаяг: audit@azure.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.14 № 07/1015
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Санхүүгийн мэдээллийн технологийн төв” УТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн өмнөх оны тушаал, шийдвэрийг үндэслэж урамшуулал олгосон, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй нийт 58.4 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 16 дугаар зүйлийн 16.5, 16.5.5, 26 дугаар зүйлийн 26.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.1.4, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.11, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 23.2, Сангийн сайдын 2022 оны 185 дугаар тушаалын хавсралтын 6.4-д заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын тохиолдсон байх, тасалбар болголт, үнэлгээ ба хуваарилалт, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Сангийн яамтай байгуулсан 2023 оны 1-033 тоот гэрээний дагуу "Төсвийн болон санхүүгийн тогтвортой байдлыг бүрдүүлэх төсөл"-ын зөвлөх үйлчилгээний ажлыг гүйцэтгэж 47.5 сая төгрөгийн нэмэлт орлого олсон байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Батлагдсан төсөвт үндсэн цалинг бөөн дүнгээр 4,439.7 сая төгрөгөөр төсөвлөсөн бөгөөд гүйцэтгэлээр 3,954.7 сая төгрөгийг үндсэн цалин, 145.8 сая төгрөгийг нэмэгдэл цалин, 147.2 сая төгрөгийг унаа хоолны хөнгөлөлт, 184.6 сая төгрөгийг урамшуулалд зарцуулж, нийт дүнгээр 4,432.3 сая төгрөгийг зарцуулж, 7.4 сая төгрөгийг хэмнэсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн мэдээллийн технологийн төв УТҮГ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа хуулийн хугацаандаа ирүүлж, Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасны дагуу аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг саадгүй гаргаж ирүүлсэн.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлтэд бусад мэдээлэл хэсэгт тусгасан асуудал нь хамрахгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	23,076,660.00	49,674,747.05
33	АВЛАГА	-	3,459,419.98
335	Бусад авлага	-	3,459,419.98
3351	Байгууллагаас авах авлага	-	935,719.99
3352	Хувь хүмүүсээс авах авлага	-	2,523,699.99
35	БАРАА МАТЕРИАЛ	23,076,660.00	46,215,327.07
354	Хангамжийн материал	23,076,660.00	46,215,327.07
35410	Бичиг хэргийн материал	5,459,746.00	4,818,259.43
35450	Аж ахуйн материал	9,768,514.00	38,144,267.64
35470	Бусад хангамжийн материал	7,848,400.00	3,252,800.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,318,338,660.05	1,187,109,781.97
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,318,338,660.05	1,187,109,781.97
392	Биет хөрөнгө	1,046,792,494.89	970,822,428.57
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	1,992,084,338.70	2,226,536,258.70
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,018,797,306.16)	(1,358,345,917.24)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	124,210,281.11	148,584,215.91
39208	Хуримтлагдсан элэгдэл	(66,887,790.88)	(72,334,023.95)
39214	Бусад үндсэн хөрөнгө	23,157,084.00	41,621,221.76
39215	Хуримтлагдсан элэгдэл	(6,974,111.88)	(15,239,326.61)
393	Биет бус хөрөнгө	271,546,165.16	216,287,353.40
39301	Программ хангамж	272,177,373.00	272,177,373.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(631,207.84)	(55,890,019.60)
39303	Бусад биет бус хөрөнгө	11,519,250.00	11,519,250.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(11,519,250.00)	(11,519,250.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,341,415,320.05	1,236,784,529.02
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	42,829,599.87	26,280,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	42,829,599.87	26,280,000.00
413	Өглөг	42,829,599.87	26,280,000.00
41310	Ажилчидтай холбоотой өглөг	-	26,280,000.00
4136	Бусад өглөг	42,829,599.87	-
41361	Байгууллагад төлөх өглөг	8,473,992.19	-
41365	ХХОАТ - ийн өглөг	34,355,607.68	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,298,585,720.18	1,210,504,529.02
51	Засгийн газрын хувь оролцоо	1,298,585,720.18	1,210,504,529.02
512	Хуримтлагдсан үр дүн	1,298,585,720.18	1,210,504,529.02
51210	Өмнөх үеийн үр дүн	1,228,913,688.40	1,298,585,720.18
51220	Тайлант үеийн үр дүн	69,672,031.78	(88,081,191.16)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,341,415,320.05	1,236,784,529.02

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,370,496,550.00	7,077,761,318.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	245,000.00	625,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	245,000.00	625,000.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	-	100,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	100,000.00
120009	Бусад орлого	245,000.00	525,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,370,251,550.00	7,077,136,318.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	5,370,251,550.00	7,077,136,318.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,281,940,300.00	7,029,568,300.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	88,311,250.00	47,568,018.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,300,824,518.22	7,164,068,118.79
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,300,824,518.22	7,164,068,118.79
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,113,781,894.95	6,905,614,124.54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,217,724,502.17	4,420,341,784.99
210101	Үндсэн цалин	2,638,386,207.42	3,942,696,978.35
210102	Нэмэгдэл	225,332,130.05	145,769,237.59
210103	Унаа хоолны хөнгөлөлт	124,404,364.70	147,259,322.51
210104	Урамшуулал	229,601,800.00	184,616,246.54
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	396,986,463.14	569,966,000.00
210201	Тэтгэврийн даатгал	285,063,100.00	403,576,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	27,974,800.00	41,597,300.00
210203	ҮОМШ өвчний даатгал	23,465,800.00	20,798,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	5,595,000.00	20,798,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	54,887,763.14	83,194,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	228,210,019.17	356,455,803.76
210301	Гэрэл цахилгаан	31,992,869.04	29,430,000.00
210302	Түлш, халаалт	17,538,458.08	6,110,956.14
210303	Цэвэр, бохир ус	7,078,692.05	-
210304	Байрны түрээс	171,600,000.00	320,914,847.62
2104	Хангамж, бараа материалын зардал	12,406,790.55	357,315,487.69
210401	Бичиг хэрэг	4,317,656.67	4,916,002.66
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	2,832,233.88	2,342,145.25
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,256,900.00	-
210408	Бараа материал акталсны зардал	-	350,057,339.78
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,486,020.00	12,936,200.00
210601	Багаж, техник хэрэгсэл	6,486,020.00	12,936,200.00
2107	Томилолт, зочны зардал	41,001,917.68	21,388,375.00
210701	Гадаад албан томилолт	31,271,817.68	14,633,575.00
210702	Дотоод албан томилолт	9,730,100.00	6,754,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	770,512,290.17	940,269,063.71
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	758,546,249.75	927,015,285.94
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	11,966,040.42	13,253,777.77
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	440,453,892.07	226,941,409.39
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	58,838,484.27	68,301,113.70
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	39,302,828.44	91,811,590.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал	342,312,579.36	66,828,705.69

Санхүүгийн мэдээллийн технологийн төв УТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	187,042,623.27	258,453,994.25
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	128,865,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	128,865,000.00
2133	Татаас	187,042,623.27	129,588,994.25
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	187,042,623.27	129,588,994.25
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	69,672,031.78	(86,306,800.79)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	1,774,390.37
225001	Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	-	1,774,390.37
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(1,774,390.37)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	69,672,031.78	(88,081,191.16)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	5,472,333,313.14	7,077,761,318.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	245,000.00	625,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	245,000.00	625,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	100,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	100,000.00
120009	Бусад орлого	245,000.00	525,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,472,088,313.14	7,077,136,318.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	5,281,940,300.00	7,029,568,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,281,940,300.00	7,029,568,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	190,148,013.14	47,568,018.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	190,148,013.14	47,568,018.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	4,924,364,777.14	6,790,329,760.24
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,924,364,777.14	6,790,329,760.24
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,737,322,153.87	6,532,355,765.99
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	3,183,368,894.49	4,432,356,812.65
210101	Үндсэн цалин	2,604,030,599.74	3,954,712,006.01
210102	Нэмэгдэл	225,332,130.05	145,769,237.59
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	124,404,364.70	147,259,322.51
210104	Урамшуулал	229,601,800.00	184,616,246.54
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	396,986,463.14	569,966,000.00
210201	Тэтгэврийн даатгал	285,063,100.00	403,576,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	27,974,800.00	41,597,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	23,465,800.00	20,798,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	5,595,000.00	20,798,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	54,887,763.14	83,194,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	228,210,019.17	364,206,963.76
210301	Гэрэл, цахилгаан	31,992,869.04	29,430,000.00
210302	Түлш, халаалт	17,538,458.08	6,110,956.14
210303	Цэвэр, бохир ус	7,078,692.05	-
210304	Байрны түрээс	171,600,000.00	328,666,007.62
2104	Хангамж, бараа материалын зардал	8,912,773.88	5,636,795.25
210401	Бичиг хэрэг	1,263,800.00	3,294,650.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,832,233.88	2,342,145.25
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,816,740.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,208,600.00	21,392,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	13,208,600.00	21,392,600.00
2107	Томилолт, зочны зардал	41,001,917.68	21,388,375.00

Санхүүгийн мэдээллийн технологийн төв УТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210701	Гадаад албан томилолт	31,271,817.68	14,633,575.00
210702	Дотоод албан томилолт	9,730,100.00	6,754,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	772,371,232.07	959,304,767.33
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	760,405,191.65	944,623,377.06
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	11,966,040.42	14,681,390.27
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	93,262,253.44	158,103,452.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	56,338,425.00	61,499,862.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	36,923,828.44	96,603,590.00
212	ТАТААС	187,042,623.27	129,588,994.25
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	116,481,373.27	129,580,976.25
213305	Нэмэлт санхүүжилт - төвлөрүүлэх шилжүүлэг	70,561,250.00	8,018.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	128,385,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	128,385,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	128,385,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	547,968,536.00	287,431,557.76
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	547,968,536.00	287,431,557.76
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	547,968,536.00	287,431,557.76
2200	Дотоод эх үүсвэрээр	547,968,536.00	287,431,557.76
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	547,968,536.00	287,431,557.76
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(547,968,536.00)	(287,431,557.76)

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-	-	1,228,913,688.40	1,228,913,688.40
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	1,228,913,688.40	1,228,913,688.40
Тайлант үеийн үр дүн	-	-	69,672,031.78	69,672,031.78
2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-	-	1,298,585,720.18	1,298,585,720.18
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	1,298,585,720.18	1,298,585,720.18
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Хөрөнгө оруулалтын өсөлт, бууралт	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(88,081,191.16)	(88,081,191.16)
2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-	-	1,210,504,529.02	1,210,504,529.02

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон
СНАГ-2025/043/НА-СТА-ТӨҮГ

/төгрөгөөр/

Санхүүгийн мэдээллийн технологийн төв УТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,029,568,300.00	6,900,612,323.75	128,955,976.25	98.2
УРСГАЛ ЗАРДАЛ	7,029,568,300.00	6,900,612,323.75	128,955,976.25	98.2
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,901,183,300.00	6,772,227,323.75	128,955,976.25	98.1
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	4,439,728,000.00	4,432,356,812.65	7,371,187.35	99.8
Үндсэн цалин	4,439,728,000.00	3,954,712,006.01	485,015,993.99	89.1
Нэмэгдэл	-	145,769,237.59	(145,769,237.59)	-
Унаа хоолны Хөнгөлөлт	-	147,259,322.51	(147,259,322.51)	-
Урамшуулал	-	184,616,246.54	(184,616,246.54)	-
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	569,966,000.00	569,966,000.00	-	100.0
Тэтгэврийн даатгал	403,576,900.00	403,576,900.00	-	100.0
Тэтгэмжийн даатгал	41,597,300.00	41,597,300.00	-	100.0
ҮОМШӨ-ний даатгал	20,798,600.00	20,798,600.00	-	100.0
Ажилгүйдлийн даатгал	20,798,600.00	20,798,600.00	-	100.0
Эрүүл мэндийн даатгал	83,194,600.00	83,194,600.00	-	100.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	394,691,300.00	364,206,963.76	30,484,336.24	92.3
Гэрэл, цахилгаан	29,430,000.00	29,430,000.00	-	100.0
Түлш, халаалт	16,658,000.00	6,110,956.14	10,547,043.86	36.7
Цэвэр, бохир ус	11,772,000.00	-	11,772,000.00	-
Байрны түрээс	336,831,300.00	328,666,007.62	8,165,292.38	97.6
Хангамж, бараа материалын зардал	5,886,000.00	5,636,795.25	249,204.75	95.8
Бичиг хэрэг	2,943,000.00	3,294,650.00	(351,650.00)	111.9
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,943,000.00	2,342,145.25	600,854.75	79.6
Эд хогшил, урсгал засварын зардал	333,920,000.00	273,111,657.76	60,808,342.24	81.8
Багаж, техник, хэрэгсэл	333,920,000.00	273,111,657.76	60,808,342.24	81.8
Томилолт, зочны зардал	44,697,000.00	21,388,375.00	23,308,625.00	47.9
Гадаад албан томилолт	39,192,000.00	14,633,575.00	24,558,425.00	37.3
Дотоод албан томилолт	5,505,000.00	6,754,800.00	(1,249,800.00)	122.7
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	999,480,000.00	992,752,267.33	6,727,732.67	99.3
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	984,765,000.00	978,070,877.06	6,694,122.94	99.3
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	14,715,000.00	14,681,390.27	33,609.73	99.8
Бараа үйлчилгээний бусад зардал	112,815,000.00	112,808,452.00	6,548.00	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	63,765,000.00	63,764,862.00	138.00	100.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага	49,050,000.00	49,043,590.00	6,410.00	100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	128,385,000.00	128,385,000.00	-	100.0
Бусад урсгал шилжүүлэг	128,385,000.00	128,385,000.00	-	100.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	128,385,000.00	128,385,000.00	-	100.0

ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	7,029,568,300.00	6,900,612,323.75	128,955,976.25	98.2
---------------------------------------	-------------------------	-------------------------	-----------------------	-------------

Санхүүгийн мэдээллийн технологийн төв УТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	7,029,568,300.00	6,899,987,323.75	129,580,976.25	98.2
Улсын төсвөөс санхүүжих	7,029,568,300.00	6,899,987,323.75	129,580,976.25	98.2
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	625,000.00	(625,000.00)	-
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	-	-	-
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	625,000.00	(625,000.00)	-
БУСАД ЭХ ҮҮСВЭР	-	-	-	-
Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	-	-	-	-
Байгууллагын тоо	1	1	-	100.0
Төсвийн байгууллага	1	1	-	100.0
АЖИЛЛАГСДЫН ТОО	78	78	-	100.0
Удирдах ажилтан	1	1	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	77	77	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	47,560,000.00
УРСГАЛ ЗАРДАЛ	-	47,560,000.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	47,560,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	-	47,560,000.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага	-	47,560,000.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	47,560,000.00
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	47,560,000.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	47,560,000.00

3. АУДИТЫН ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТЛЭ

3.1 Аудитаар нийт 28.8 сая төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ажилчдаас авах 2.5 сая төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд тусгаж, толилуулаагүй байна.	1	2,523.6	1	2,523.6	-	-	1	2,523.6	-	-	-	-
Ажилчдад өгөх 26.3 сая төгрөгийн өглөгийг санхүүгийн тайланд тусгаж, толилуулаагүй байна.	1	26,280.0	1	26,280.0	-	-	1	26,280.0	-	-	-	-
Дүн	2	28,803.6	2	28,803.6	-	-	2	28,803.6	-	-	-	-

/мянган төгрөгөөр/

3.2 Аудитаар нийт 58.4 сая төгрөгийн 3 зөрчил² илэрснээс, 37.6 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 20.8 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Гүйцэтгэх захирлын 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 108 дугаар тоот тушаалыг үндэслэн тайлант онд ажилчдад 20.8 сая төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон байна.	1	20,828.0					1	20,828.0				
Сургалт зохион байгуулах арга хэмжээнд тушаал гаргаж, төсөв баталсан ч гүйцэтгэлээр тушаалд тусгагдаагүй 37.6 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.	1	37,600.0			1	37,600.0						

/мянган төгрөгөөр/

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Санхүүгийн мэдээллийн технологийн төв УТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Өөрийн чиг үүрэгт хамааралгүй төлбөрийн баримтын сугалааны тохирлын үйл ажиллагааг хариуцан зохион байгуулж, тайлант онд 59.8 сая төгрөгийн зардал гаргасан байна.	1	-			1	-						
Дүн	3	58,428.0			2	37,600.0	1	20,828.0				

3.3 АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудлаар 1 зөрчил³ илэрснээс 1 зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитын нийцлийн асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/			
			Үүнээс		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Худалдан авах ажиллагаанд оролцож буй мэргэжилтэн ашиг сонирхлын зөрчилгүй талаар мэдэгдлийг худалдан авах ажиллагааны үнэлгээний хорооны гишүүнээр томилогдсон тухай бүрд гаргаагүй байна.	1	-	-	-	1	-
Дүн	1	-	-	-	1	-

³ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.